

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 08 дугаар сарын 22		Улаанбаатар хот		
Дүд	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
	Үүрэг, даалгавар НЭГ: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилогдсоноос хойших хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хийсэн ажлын хэрэгжилт, үр дүнг нэгтгэн танилцуулах.			
1	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг тус тус 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр ichinnorov.b@ulaanbaatar.mn цахим хаягаар илгээсэн. Нийслэлийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 03/2368 тоот албан бичгээр, мэргэжилтэн Б.Цогзолцэрмаа (ERP) хаягаар хүргүүлсэн.			90
	Үүрэг, даалгавар ХОЁР: Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, хяналт тавих.			
2	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт ажилтан, албан хаагчдын ирц, цаг ашиглалт, ажлын байрны сахилга батад тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд төрийн албан хаагчдад зориулсан ёс зүй, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зөвлөгөөг үе шаттайгаар зохион байгуулж байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдүүлэх чиглэлээр Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хамтран хяналтыг тогтмол тавин ажиллаж байна			90
	Үүрэг, даалгавар ГУРАВ: Төрийн захиргааны албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлтийн талаар санал боловсруулж танилцуулах.			
3	Төрийн захиргааны албан хаагчдын тоог бууруулах талаар холбогдох судалгааг хийж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			30
	Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд инженер хангамжийн ажлуудыг эрчимжүүлж, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах.			
4	-Дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Элбэг дулаан" ХХК нь дүүргийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль, сургуулийн өмнөх боловсролын 103, 247			50

	<p>дугаар цэцэрлэг, 18 дугаар хорооны цогцолбор байр, хорооны 6 аж ахуйн нэгж, байгууллагыг дулаанаар ханган ажилладаг бөгөөд Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу нийт 2.8 мегаватт хүчин чадал бүхий 2 уурын зуухыг хийн түлшээр халаахаар төлөвлөн уурын зуухаа шинэчлэн ажиллаж байна. 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар уурын зуух шинэчлэлтийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус уурын зуухнаас халаалтаа авдаг дүүргийн 247 дугаар цэцэрлэг нь дулаан алдагдал ихтэй бөгөөд халаалтын зардал өндөр гарах эрсдэлтэй учраас дулаан алдагдлыг бууруулах зардлыг шийдвэрлэх нэн шаардлагатай байна.</p> <p>“Ану сервис” ХХК нь уурын зуухаар 13 дугаар хорооны цогцолбор байр, дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн Хайлааст дахь тасгийн барилга, Ерөнхий боловсролын 17, 49, 72 дүгээр сургууль, сургуулийн өмнөх боловсролын 56 дугаар цэцэрлэг болон зарим айл өрхийг дулаанаар ханган ажилладаг. Дээрх байгууллагуудыг дулаанаар хангадаг 3.9 мегаватт хүчин чадал бүхий 26, 49, 72 дугаар уурын зуухуудыг Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу хийн түлшээр халаахаар төлөвлөн уурын зуухаа шинэчлэн ажиллаж байна. 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар уурын зуух шинэчлэлтийн ажил 20 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус уурын зуухнаас халаалтаа авдаг дүүргийн 49 дүгээр сургуулийн дотор халаалтын системийг засаж шинэчлэх шаардлагатай байгаа бөгөөд уг ажлын хүрээнд сантехникийн их засварын ажлын зураг төслийг “Стийл проект” ХХК гүйцэтгэн ажиллаж байна. Уг сантехникийн их засварын ажлыг гүйцэтгэх төсвийн зардал батлагдаагүй тул өвөлжилтийн явцад хүндрэл үүсэх өндөр эрсдэлтэй байна.</p>		
<p>Үүрэг, даалгавар ТАВ: Төсвийн орлогын төлөвлөгөөг бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх.</p>			
5	<p>2025 оны 08 дугаар сарын 19-ний байдлаар өссөн дүнгээр Улсын төсөвт 74,862,278.19 мянган төгрөг төвлөрүүлэхээс 70,966,181.74 мянган төгрөг төвлөрүүлж 94.8%, нийслэлийн төсөвт 16,583,650.88 мянган төгрөг төвлөрүүлэхээс 13,286,494.53 мянган төгрөг төвлөрүүлж 80.12%, дүүргийн төсөвт 194,427,424.90 мянган төгрөг төвлөрүүлэхээс 167,754,026.70 мянган төгрөг төвлөрүүлж 86.28%-ийн биелэлттэй байна.</p>		90
<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангуулах хяналтын камерын ажиллагааг шалгаж, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.</p>			
6	<p>Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 39 байгууллагад нийт 983 камер байгаагаас коридорт 220, ангид 509, ариун цэврийн өрөөнд 8, гадна талбайд 188 камер, Ерөнхий боловсролын 19 сургуульд нийт 951 камер байгаагаас коридорт 365, ангид 481, гадна талбайд 73 камер тус тус байна. Эдгээр 1934 камераас MNS6423-2019 стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролд 455 ширхэг камер, ЕБС-д 454</p>		90

	камер байна. Эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд 2025-2026 оны хичээлийн жилд гадна талбайд 105, дотор болон ангид 145 камер шаардлагатай байна.		
Үүрэг, даалгавар ДОЛОО:	Хүнсний зах, худалдааны төвүүдэд хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулах.		
7	Хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хүнсний зах, худалдааны төвүүдэд хяналт, шалгалтыг зохион байгуулан ажилласан. 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн 2 дугаар хороо, Алтжин бөмбөгөр худалдааны төвийн 57 түрээслэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгүй, хаяг шошгын зөрчилтэй, хадгалалтын хугацаа дууссан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн худалдан борлуулсан, жин хэмжүүр баталгаажилтгүй, хоолны газрууд стандартын шаардлага хангаагүй, батлагдсан жор технологийг мөрдөж ажилладаггүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн. Холбогдох хууль тогтоомжийн дагуу илэрсэн зөрчлийг арилгуулахаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажилласан. Хяналт, шалгалтын ажил үргэлжилж байна.		70
Үүрэг, даалгавар НАЙМ:	Авто зам, явган замуудын нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, стандарт шаардлагыг хангуулах.		
8	Дүүргийн 2 дугаар хорооны Сансар кабелийн баруун талын 600 м, кв явган замын эвдрэлтэй талбайг нөхөн сэргээж, 2 байршилд замын цөмөрсөн талбайг янзалж хэвийн байдалд шилжүүлээ. Дүүргийн 3 дугаар хороо урт цагаанаас их дэлгүүр явах явган зам, 4 дүгээр хорооны шинэ байрны зүүн талын явган замыг шинэчлэх ажил 80 хувьтай хийгдэж байна. Мөн монтелийн арын авто замыг хааж өглөөний гудамж болгох ажил дуусах шатандаа орсон. Бишрэлт зочид буудлын арын Дипломат-95 дугаар байрны баруун талын хашлагыг буулгаснаас үүдсэн явган замын эвдрэлтэй хэсгийг дахин засварлахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Баянбүрдийн тойргийн баруун хойно байрлах гүний худгийн эргэн тойрныг автозам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, явган зам болгож иж бүрнээр тохижуулах зорилгоор дүүргийн гэрээт байгууллага болох "Түк" ХХК гүйцэтгэн ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Баянбүрдийн тойрог орчимд 2 байршилд, 18 дугаар цэцэрлэгийн зүүн талд шугам засварын ажлын дараах нөхөн сэргээлт хийгдээгүй мөн 1, 3, 12, 13, 14 дүгээр байрны цахилгааны кабел шинэчлэх ажлын нөхөн сэргээлт тус тус хийгдээгүй тул Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-т нөхөн сэргээлт хийлгэх тухай албан бичиг хүргүүлсэн.		70
Үүрэг, даалгавар ЕС:	ТҮЦ-ийг нүүлгэж цэгцлэх ажлыг эрчимжүүлж, дуусгах.		

9	<p>Дүүргийн Засаг даргын 2025 оны "Газар албадан чөлөөлөх тухай" А/117 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Газар зохион байгуулалтын алба, Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Нийтлэг үйлчилгээний газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн 2, 5, 6, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайд буцаан байршуулсан нийт 6 түргэн үйлчилгээний цэгийг албадан нүүлгэж, газар чөлөөлж, үүрэг гүйцэтгэн ажилласан.</p>			100
<p>Үүрэг, даалгавар АРАВ: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хийж хэрэгжүүлж байгаа ажлаа иргэд, олон нийтэд сурталчлах.</p>				
10	<p>Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлуудыг дүүргийн цахим хуудас, chingeltei.gov.mn болон дүүргийн гэрээт 10 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэд, олон нийтэд 60 мэдээ бэлтгэн хүргэснээс 15 нь видео хэлбэрээр, үлдсэн 45 нь зурган мэдээ байна. Тайлант хугацаанд нийт 574 мянга гаруй хандалт авч, 11000 лайк, 2000 шэйр авсан байна</p>			100
<p>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах.</p>				
11	<p>2025-2026 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эзэнгүй золбин нохой устгалын ажлыг эрчимжүүлэн самналт хэлбэрээр гүйцэтгэгч байгууллага болон хороодтой хамтран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 01-нээс 21-ний өдрийн хооронд гэр хорооллын 7-24 дүгээр хороонд нийт 793 эзэнгүй нохойг устгалд оруулан төвлөрсөн хогийн цэгт булж устгуулсан.</p>			100
<p>ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</p>				80

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ТАМИР



ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НАВЧАА



НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

